ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**Аудитын код:** **САГ-2018/113/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК
Ерөнхий захирал Д.Түмэнжаргал
Ахлах аудитор Ц.Алтанхуяг
Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Улаанбаатар хот

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ..... 1
2 Аудитын тайлан ..... 3
2.1 Оршил ..... 3
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 3
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 4
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 4
2.5 Дотоод хяналт ..... 5
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 6
2.7 Шилэн дансны мэдээлэл ..... 7
2.8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ..... 8
2.9 Гол онцлох гүйлгээ ..... 9
2.10 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар ..... 9
2.11 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл ..... 10
2.11.1 Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн талаар ..... 10
2.11.2 Цалингийн зардлын таалаар 11
2.11.3 Нэг удаагийн тэтгэмж урамшууллын талаар ..... 12
2.11.4 Үндсэн хөрөнгө, бараа, ажил үйлчилгээний худалдан авалтын талаар ..... 13
2.11.5 Туслах үйл ажиллагааны орлогын талаар 14
2.12 Анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 15
2.13 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд 15
2.14 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл ..... 15
2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
2.16 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: ..... 16
2.17 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 16
3 Менежментийн захидал ..... 17
3.1 Цалингийн сан, орон тооны хязгаарын талаар ..... 18
3.2 Шилэн дансны мэдээлэл ..... 19
3.3 Цалингийн зардал ..... 20
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 21
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ..... 21
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 23
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 27
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 27
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 28

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.04.06 № 06/910

танай ____________-ны № ____________-т

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г.БАТБААТАР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдах зөвлөлийн дарга Т.Ган-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд сургуулийн орон тооны хязгаар, цалинийг санг Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тогтоолгох, “Шилэн дансны тухай” хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, багш нарын гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг харъяалагдах сургуулийн санхүүгээс олгож, дотоод хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого , журмын дагуу материаллаг алдаагүй , үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан , төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 5-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн Ерөнхий захирал Д.Түмэнжаргал, ахлах аудитор Ц.Алтанхуяг, аудитор Ш.Нурдаулет, аудиторын туслах Б.Ганчимэг нар хэрэгжүүлж ажиллав.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 1/440 дугаартай албан бичгээр санхүүгийн тайлангийн аудит хийлгэх хүсэлтээ Монголиан бизнес рейтинг аудит ХХК-д ирүүлсэн болно. Аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 19-ны өдөр байгууллагын удирдлагад гардуулна.

## 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь “Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ , боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг болох” гэсэн эрхэм зорилготой ажиллаж байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, эрдэмтэн судлаачдын хамтын хөдөлмөрийн дүнд хүний их эмч бэлтгэх хөтөлбөр олон улсын эрх бүхий ASIIN байгууллагаар магадлан итгэмжлүүлж анагаах ухааны боловсрол нь олон улсын түвшинд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөж, гадаадын олон улс орнуудаас оюутан залуус элсэн суралцдаг, төгсөгчид нь дэлхийн аль ч улс оронд сурч, ажиллах эрхтэй болж Монгол улсын дээд боловсролын нэрийн хуудас болсон үндэсний шилдэг их сургуулийн нэг болсон байна.

Монгол улсад анх удаа Их Сургуулийн Эмнэлэг, Сургалтын шинэ цогцолбор байгуулахаар төсөл боловсруулж, Япон улсын буцалтгүй тусламжаар Монгол Япон Сургалтын Эмнэлгийг барьж 2018 онд, өөрийн хөрөнгөөр Эмнэлэг Сургалтын шинэ цогцолборын эхний хэсэг болох Анагаах Ухааны Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн хичээлийн шинэ байрыг 2018 онд барьж ашиглалтанд бүрэн оруулах, сургалтын цогцолборын II хэсэг 1600 оюутны байр, соёл спортын цогцолбор, багш ажилчдын байрыг 2018-2019 онуудад барьж эхлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Дээд боловсролын тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “ Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

## 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төрийн өмчийн байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг төлөвлөлтийн шатанд тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 31,276.3 сая төгрөгийн 2 хувиар тооцож 625.5 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагаанд 2017 оны эхний хагас жилд “Ординат” ХХК-ийн боловсруулсан “Винница” санхүүгийн програмыг ашигласан. Сүүлийн хагас жилд санхүүгийн програмын сайжруулалт, шинэчлэлт хийж, мөн компанийн “Unicus” програмыг худалдан авч ашигласан байна. Иймд 2 програмын тайлагналын дүнг Excel програмаар нэгтгэн жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргасан байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт үнэлгээнд өөрчлөлт ороогүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3- д “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна” гэж заасантай нийцүүлэн Эрүүл мэнд шинжлэх ухааны сургуулийн ( тухайн үеийн нэр) захирлын 2013 оны А/56 дугаар тушаалаар “Дотоод аудитын дүрэм журам“,“Дотоод аудитын ажилтны ёс зүйн дүрэм“, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”, “Аудитын ажилтны нийтлэг эрх үүрэг”-ийг тус тус баталсан байна. Дотоод аудит хяналтын нэгж нь 2017-2018 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний биелэлт, шалгалтын ажлын тайланг сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр зөвлөмж гарган холбогдох нэгжүүдэд хугацаатай албан даалгавар өгч, биелэлтийг гаргуулан авч ажилласан байна. Дотоод аудитын алба нь 2017-2018 онд шалгалт явуулах төлөвлөгөө, ажлын хуваарийн дагуу 25 нэгжид төлөвлөгөөт 6, төлөвлөгөөт бус 7 нийт 13 дотоод аудит хийж, холбогдох нэгжүүдэд 14 албан тоотоор 31 зөвлөмж хүргүүлснээс 30 зөвлөмжийн хариуг авч, 96 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Сувилахуйн сургуулийн Захирал Наранбаатарт хүргүүлсэн Өөжин мед компанитай холбоотой санхүүгийн зөрчлийн зөвлөмжийн хариу ирээгүй байна.

Хүргүүлсэн 31 зөвлөмжийг чиг үүргийн дагуу ангилахад дараах байдалтай байна:

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Санхүү эдийн засгийн чиглэлээр
5 Тендер,худалдан авалт 4
Сургалт 6 Эрдэм шинжилгээ 2
Эмнэл зүй 5

Зохион байгуулалт
4 Бусад 4

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-д заасны дагуу захирал, ерөнхий нягтлан бодогч нар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутамын хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

## 2.6 Төрийн байгууллагын орлого зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугээр сарын 22-ны өдрийн 001 тогтоолоор 2017 оны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөг хэлэлцэж баталсан байна.

*Орлогын гүйцэтгэл:* 2017 оны орлогын төлөвлөгөө нийт **32,310.0** сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр нийт **31,276.3** сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 3,2 хувиар буюу 1,033.7 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 12,8 хувиар буюу 6,546.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Үүнээс үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,520.8 сая төгрөгөөр өссөн боловч, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,900.9 сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөгөө 1,033.8 сая төгрөгөөр тасархад гол нөлөө үзүүлсэн байна.

Нийт орлогын 92 хувь буюу **28,756.2** сая төгрөгийг өөрийн үндсэн болон туслах үйл ажиллагаанаас, 8 хувь буюу 2,520.0 сая төгрөгийг төсвийн санхүүжилт болон бусад эх үүсвэрээр бий болсон байна.

Улсын төсвийн санхүүжилтээр байр ашиглалтын зардалд /халаалт, цахилгаан, ус/ 1,746.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,167.4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.Тус санхүүжилтын авлагын оны эхний үлдэгдэл 988.9 сая төгрөг, оны эцсийн үлдэгдэл 943.7 сая төгрөг байна.

Мөн Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сангаас 311.6 сая төгрөг, ахлах сургуулийн сурагчдын хувьсах зардалд 143.9 сая төгрөг, Шинжлэх ухааны технологийн сангаас 176.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна.

*Зардлын гүйцэтгэл:* 2017 онд нийт **27,450.2** сая төгрөгийн зардал батлагдаж, **26,645.1** сая төгрөгийн зарцуулалт гарч, төлөвлөгөөт зардлыг 2,9 хувь буюу 831.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Зардлын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7,6 хувиар буюу 1,897.7 сая төгрөгөөр илүү ба төлөвлөгөөтэй харьцуулахад 2,9 хувиар буюу 805.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг захирал баталж, арилжааны банк дахь харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яамны төрийн сангийн хэлтсээс тогтмол зардлын төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Орлогын батлагдсан төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг төлөвлөөгүй байна.

Аудитын явцад тус сургуульд ашиглагдаж байгаа гемаиологийн микробилогийн лабораторийн тоног төхөөрөмжинд биет тооллого хийж үзэхэд тус тоног төхөөрөмж хэвийн ашиглалттай бүрэн байлаа. Тооллого хийсэн акт тоног төрөөрөмжийн байршил, хөрөнгийн кодыг зургаар баталгаажуулсан

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульийн 2017 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх мэдээллийг шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллийг шалгаж үзэхэд орлого, зардал, удирдлагын шийдвэр, тендер шалгаруулалт, худалдан авалт зэрэг онцлох ажил гүйлгээний талаарх мэдээллийг www.shilendans.gov.mn/ сайтад байршуулж олон нийтэд толилуулж байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь шилэн дансны нэгдсэн цахим системд 2017 онд 19 төрлийн мэдээллийг жил, улирал, сар, тухай бүр гэсэн давтамжтайгаар 142 удаа мэдээлэхээс 19 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 80 мэдээллийг хугацаа хожимдуулж, 43 мэдээллийг мэдээлээгүй байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тус байгууллагын цахим хуудсанд байршуулсан зарим мэдээллийг сонгон авч нарийвчлан шалгахад дараах дүнтэй байна. Үүнд:

1. “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” гэсэн талбарт 5 төрлийн мэдээллийг байршуулах ёстой бөгөөд аудитаар 4 төрлийн мэдээллийг хангалтгүй мэдээлсэн зөрчил илэрлээ.

- Тус сургуулийн удирдлага худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлаагүй;
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг мэдээллээгүй;
- тус сургууль улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 нэр төрлийн 2,800.0 сая төгрөгийн 5 тендерийн зарлаж, сонгон шалгаруулалт хийсэн боловч тендер шалгаруулалтын дүнг мэдээллээгүй;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасны дагуу 7 хоногийн дотор мэдээлэх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг шалгахад нийт 30 удаагийн гүйлгээг мэдээлсэн байна;
- Худалдан авах ажиллагааны тайланг шалгаруулалт хийсэн тендер тус бүрээр бичсэн хэдий ч тайланг 2018 оны 1 дүгээр сарын 15-ны дотор шилэн дансанд мэдээллээгүй;

2.“Бусад мэдээлэл” гэсэн талбарт 6 төрлийн мэдээллийг байршуулах ёстой бөгөөд аудитаар 3 төрлийн мэдээллийг хангалтгүй мэдээлсэн зөрчил илэрлээ.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан ашиг сонирхлын мэдэгдлийг гэрээ хэлцэл байгуулах, төсвийн хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэр гаргах бүртээ, 7 хоногийн дотор шилэн дансанд байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад тайлант онд 37 удаагийн 676.2 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай тушаал шийдвэрийг гаргасан боловч мэдэгдэл, шийдвэрүүдийг байршуулаагүй;
Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг бүтэн жилээр нэг удаа шилэн дансанд байршуулах ёстой боловч "байхгүй" гэж тайлагнасан, тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 9 зөвлөмж өгсөн байтал шилэн дансанд зөвлөмжийн биелэлтийг тайлагнаагүй байна.

Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

## 2.8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Аудитад Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагын олон улсын стандарт (СТОУС) болон холбогдох Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн зүйл заалтыг шалгуур болгон авав.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" -ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", мөн 2008 оны тушаалаар батлагдсан 2 дугаар хавсралтын "Цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан" СТ4А, "Төсвийн гүйцэтгэлийн тайлан" бэлтгэх заавар"-ын дагуу Нягтлан бодох бүртгэлийн горим, дансдын нийтлэг бичилт, жишиг жагсаалт, нэгдсэн кодчилол зэрэгт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн төрийн байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журамтай нийцэж байна.

Тус сургуулийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн програм хангамжийн үйл ажиллагааг ярилцлага асуулгын аргаар судлав. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхэд хэрэглэж байгаа "Ординат" ХХК -ийн боловсруулсан "Винница" санхүүгийн програмыг 2017 оны эхний хагас жилд ашиглаж байгаад сүүлийн хагас жилд санхүүгийн програмын сайжруулалт, шинэчлэлт хийж мөн компанийн "Unicus" програмыг худалдан авч, сүүлийн хагас жилийн санхүүгийн тайланг гаргасан байна. Иймд дээрх 2 програмын тайлагналын дүнг Excel програмаар нэгтгэн жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргасан байна. " Юникус" програм хангамжийн мэдээлэл боловсруулалтын үр дүн нь Монгол улсын хууль, НББОУС-д нийцүүлж боловсруулсан журам, зааварт нийцэж байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.9 Гол онцлох гүйлгээний талаар

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд тусгагдсан онцгой үйл явдал, санхүүгийн тайлагналд нөлөөлөхүйц хэмжээний томоохон дүнтэй хийгээд аудиторын анхааралд өртсөн онцлог, том дүнтэй ажил гүйлгээ бүрийг эрэмбэлэн шүүх аргаар судлав . Ийм ажил гүйлгээний хувьд анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгө, эх үүсвэрийн дансдад гарсан өөрчлөлт, хөдөлгөөн, аж ахуйн үйл явдал, ажил гүйлгээг тохирох батламж мэдэгдлийн шалгуураар авч үнэлсэн болно.

1. Монгол улсад анх удаа Их сургуулийн эмнэлэг, Сургалтын шинэ цогцолбор байгуулахаар төсөл боловсруулж, Япон улсын буцалтгүй тусламжаар Монгол Япон Сургалтын Эмнэлгийг барьж 2018 онд, өөрийн хөрөнгөөр Эмнэлэг Сургалтын шинэ цогцолборын эхний хэсэг болох Анагаах Ухааны Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн хичээлийн шинэ байрыг 2018 онд барьж ашиглалтанд бүрэн оруулах бөгөөд сургалтын цогцолборын II хэсэг 1600 оюутны байр, соёл спортын цогцолбор, багш ажилчдын байрыг 2018-2019 онд барьж эхлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ цогцолборыг ашиглалтанд оруулснаар Их сургуулийн цогцолбор Монгол улсад анх удаа бий болгох юм байна.

   Энэ цогцолборын сургалтын зориулалттай хичээлийн 2 байрыг өөрийн хөрөнгийн санхүүжилтээр барьж байна. Дуусаагүй барилгын үлдэгдэл 2017 оны эхэнд 4,443.5 сая төгрөг, оны эцэст 8,138.9 сая төгрөг болж, тайлант хугацаанд 3,695.3 сая төгрөгөөр нэмэгсэн байна. Тайлант онд 1,559.2 сая төгрөгийн өртөг бүхий Нүүр ам судлалын сургуулийн өргөтгөлийг улсын комиссын актын дагуу ашиглалтанд хүлээн авч дуусаагүй барилгын үлдэгдлээс хөрөнгөнд шилжүүлж бүртгэсэн байна. Эдгээр хөрөнгө оруулалтын өөрийн хөрөнгийн санхүүжилтыг АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан төсвийн дагуу гүйцэтгэсэн байна.

2. 2017 оны жилийн эцэст 3,229.2 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа ба энэхүү авлагын дийлэнх хувийг сургалтын төлбөрийн авлага (1,175.5 сая төгрөг), хадгаламжийн хүүгийн авлага (700.3 сая төгрөг), БСШУСЯ-наас авах тогтмол зардлын санхүүжилтийн авлага (943.7 сая төгрөг), боловсролын зээлийн сангаас авах авлага (228.2 сая төгрөг) зэрэг байна. Аудиторын зүгээс хүүгийн авлага, тогтмол зардлын санхүүжилтийн авлага, боловсролын зээлийн сангийн авлагын үлдэгдэлд хөндлөнгийн тулган баталгаажуулалт хийж үлдэгдлийг баталгаажуулсан.

3. 2017 оны жилийн эцэст 5,737.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна, Энэхүү өглөгийн дийлэнх буюу 97,2 хувийг сургалтын төлбөрийн урдчилж орсон орлого (5,575.2 сая төгрөг) бүрдүүлж байна. Энэ нь тайлант онд оюутны сургалтын төлбөрийг аккрэул сууриар бүртгэж, 2017-2018 оны хичээлийн сургалтын төлбөрийн 2018 онд ногдох хэсгийн урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрсөн бүртгэснээс үүсэн өглөг байна. Аудиторын зүгээс өглөгийн үлдэгдлийн баталгаажуулалтыг хянасан.

## 2.10 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 21 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хөтөлбөрт данс бүрээр нийт 25 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.11 АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого, тогтмол зардал, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, тэтгэмж, урамшуулал, тендер бараа үйлчилгээний худалдан авалт, шилэн данс, татвар зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллыг тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх болон нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав. /ТАБ-СТА-В-3/

### 2.11.1 **Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн талаар**

1. Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө бэлтгэсэн 807.8 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг, үндсэн үйл ажилгааны мөнгөн гүйлгээ хэсэгт тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, санхүүгийн тайлан, тодруулгын маягтын загварыг хэрэгжүүлээгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулах бичилт хийсэн.

2. Хаан, Чингис хаан, Капитал, Үндэсний хөрөнгө оруулалтын банкуудад 2017 онд нийт 15,344.0 сая төгрөгийн хадгаламж байршуулсан бөгөөд хадгаламжийн гэрээнд заасан хугацаа, хүүгийн түвшинд үндэслэн тооцоход 2017 оны жилийн эцсийн дүнгээр 700.3 сая төгрөгийн хүүгийн орлогыг аккруэл сууриар санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулах бичилт хийсэн.

3. Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 2900014097 тоот төгрөгийн хадгаламжийн дансанд 2018 оны 1 дүгээр сарын 11-ны 01/01-89 тоот албан бичгээр ирүүлсэн банкны үлдэгдлийн баталгаагаар 2,081.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад санхүүгийн тайланд 2,000.0 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнаж, 81.3 сая төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогыг замд яваа орлогоор бүртгэсэн байна. Энэ нь Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан тус сургуулийн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” –ийн 3.1.1-д Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн бүртгэлийн “Хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хүлээн зөвшөөрөн, сар бүр тооцож мөнгөөр төлөгдөөгүй байсан ч хуримтлуулж бүртгэнэ, хуримтлуулсан хүү төлөгдөхөд харилцах/хадгаламж – Дт, дансны авлага-Кт гэж бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулах бичилт хийсэн.

4. Их сургуулийн захирлын 8 удаагийн “Б” тушаалаар 92 ажилтанд 16.5 сая төгрөгийн нэг удаагийн шагнал урамшуулал олгож, ХХОАТ ногдуулж суутгасан боловч санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж тайлагнаагүй 1.7 сая төгрөгийн татварыг мэдүүлж тайлагнаагүй банйа. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулах бичилт хийсэн;



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.11.2 **Цалингийн зардлын талаар**

1. Тус сургуулийн 2017 оны төсвийн орлого, зардлын төлөвлөгөөг Удирдах зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор баталж, цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардлыг 17,495.2 сая төгрөгөөр тогтоосон нь БСШУС-ын сайдын 2017 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д “Сургуулийн бүтэц, зохион байгуулалт, дүрэм, жишиг орон тоо, цалингийн сангийн хэмжээг сургуулийн саналыг харгалзан тогтоох” гэсэн хэдий ч энэ заалт нь төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад хамаарахгүй гэж тодотгож өгсөн, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын ... зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын шийдвэрээр сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаар, цалингийн сангийн хэмжээг жил бүр батлуулж, ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

2. Захирлын 2017 оны А/01 тоот тушаалаар албан хаагчдын 67 нэр төрлийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоохдоо Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоолоос 32 төрийн үйлчилгээний албан тушаалын ангиллыг зөрүүтэй тогтоосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т “Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасантай нийцэхгүй байна.

   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлийг тогтоосон Засгийн газрыг шийдвэрийг мөрдөж ажиллах талаар зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага хүргүүлэх.

3. Тус сургуулийн удирдах шатны 90 албан хаагчид оны эхэнд А/01 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэл олгох шийдвэр гаргаж, ур чадварын нэмэгдлийг хагас, бүтэн жилээр олгосон байна. Энэ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 5-д “ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал тутам хэлэлцэн шийдвэрлэж байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Удирдах ажилчдын ажлыг улирал тутам дүгнэж, түүний үр дүнгээр ур чадварын нэмэгдэлийг олгож байх талаар зөвлөмж хүргүүлэх.

4. Төв сургуулиас 2017 онд 7 удаа 158 багшид 97.1 сая төгрөгийн үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажлын хөлс олгосон байна. Энэ нь тус сургуулийн үндсэн багш нар Их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудад хичээл заасан тохиолдолд тухайн сургуулиас ажилласан цагийн цалин, хөлс олгох төсөв байхгүй гэсэн шалтгаанаар цалин өгдөгүй байна. Иймд бүрэлдэхүүн сургуульд хичээл заасны цалинг АШУҮИС-ийн төв сургуулиас авч, үндсэн ажлаас гадуур ажилласан иргэний нийгмийн даатгалын

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

дэвтэрт бичилт хийсэн байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “... байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно” – гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Үндсэн ажилтан хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээ байгуулахгүй байх, гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг харъяалагдах сургуулийн төсөвт батлуулж, тухайн сургуулийн санхүүгээс олгож байх зөвлөмж хүргүүлэх.

5. Хөдөлмөрийн дотоод журам болон хамтын гэрээний 2.5 дахь заалтын хүрээнд ажилчдад хоол унааны хөнгөлөлтийг тооцон олгохдоо Анагаах ухааны сургуулийн нэр бүхий 3 ажилтанд өдрийн 0.05 сая төгрөгөөр тооцож нийт 3.3 сая төгрөгийн хоол унааны мөнгө олгосон байна. Үүнийг нэг өдрийн олговол зохих батлагдсан дүнгээр дахин тооцоолоход 3.0 сая төгрөгиийн хоол, унааны хөнгөлөлтийг илүү олгосон байна. Энэ нь “Хөдөлмөрийн тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Аудитын явцад санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулсан.

6. Дорноговь аймаг дахь салбар сургуулийн захирлын гаргасан шийдвэрийн дагуу ажлаас үндэслэлгүй халагдсан нь Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 21-ны 181/ШШ2017/00006 дугаар шийдвэрээр тогтоогдож, иргэн Н.Энхтөрд 4.8 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор олгохоос 0.2 сая төгрөгийг тус сургуулийн төсвөөс олгосон байна. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 4.3-т “Хохирол, нөхөн төлбөр гаргуулах тухай”, Монгол улсын Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.1-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс гаргуулах эрхтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсанд нөхөн төлүүлэх талаар төлбөрийн акт тогтоох.

### 2.11.3 **Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын талаар**

1. Тайлант хугацаанд багш, ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшилын 20.2 сая төгрөгийн орлогоос хувь хүний орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэл ногдуулаагүй байна. Үүнд:
   - АШУҮИС нь 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Захирлын Б/39 дүгээр тушаалаар 79 ажилтанд 15.8 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон боловч үүнээс НД, ЭМД-ын шимтгэл, ХХОАТ ногдуулж суутгаагүй;
   - Эм зүй, био анагаахын сургууль нь 2017 оны 11 дугаар сарын 22-ны өдөр 7 ажилтанд лабораторийн орлогоос 3.5 сая төгрөгийн цалин олгож, НДШ ногдуулж, суутгаагүй;
   - АШУҮИС нь 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдөр худалдан авах үйл ажиллагааны тендерийн хорооны гишүүнээр ажилласан 7 ажилтанд 0.9 сая төгрөгийн ажлын хөлс олгож, ХХОАТ ногдуулж, суутгаагүй; Эдгээр нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Шимтгэлийн тайлан буюу ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл тодорхойлох хуудсыг үндэслэн шимтгэлийн тооцоог хийх бөгөөд төлбөрийг бэлэн бус тооцооны журмаар гүйцэтгэнэ”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-д “Энэ хуулийн 11.1.5-д заасан албан



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх, Татварын Ерөнхий газрын даргын 2013 оны 509 дүгээр тушаалаар батлагдсан “Хувь хүнд олгосон орлогоос суутгал хийн төсөвт шилжүүлэх заавар”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, журмын дагуу ногдуулаагүй ХХОАТ, НДШ, ЭМД-ийн шимтгэлийг нөхөн төлүүлэх талаар төлбөрийн акт тогтоох;

2. Тус сургуулийн захирал Г.Батбаатар нь 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар 1 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний 2.3 сая төгрөгийн урамшууллыг БСШУСЯ-ны 2017 оны 9 дүгээр сарын 15-ны 11/8492 тоот албан бичгийг үндэслэн захирлын тушаалаар авсан байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-дэх заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий албан тушаалтан, байгууллагад зөрчлийг мэдэгдэх;

2.11.4 **Үндсэн хөрөнгө худалдан авалтын талаар**

1. “Америк тээвэр” ХХК-тай 2017 оны 10 дугаар сарын 2-ны өдөр байгуулсан 13.9 сая төгрөгийн ном худалдан авах гэрээний дагуу хүлээн авсан хөрөнгөөс 9.0 сая төгрөгийн 23 номыг үндсэн хөрөнгөнд бүртгэж, 4.9 сая төгрөгийг сургалтын зардалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад сургалтын зардалд бүртгэсэн зардлыг ном, сурах бичиг олж бэлтгэхэд гарсан зардлаар тооцон ном, сурах бичгийн өртгийг дахин тодорхойлж орлогод авах залруулах бичилт хийсэн.

2. Нийт сургуулийн хэмжээний 15 салбар, нэгжийн бараа материалын худалдан авалтын 4, 9 дүгээр сарын орлогын дүнг нэгтгэхэд 338 иргэн, аж ахуйн нэгжээс 227.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Үүнийг Засгийн газрын Цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн тухайн сарын худалдан авалттай тулган баталгаажуулалт хийхэд 307 иргэн, аж ахуйн нэгжийн 203.1 сая төгрөгийн худалдан авалт Е баримтад бүртгэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
   Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг хийхдээ сургуулийн регистер бүхий Е-баримтыг бүрдүүлж, ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

   Тайлант хугацаанд тус байгууллага 475 нэр төрлийн 2656 ширхэг 1,489.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг 177 иргэн, 275 аж ахуйн нэгжээс бэлтгэсэн байна.

   Хангамж үйлчилгээний газраас 2017 онд 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 337.7 сая төгрөгийн 16 удаагийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

байгуулахдаа хялбаршуулан 3 байгууллагаас үнийн санал авч, түүнийгээ харьцуулан хамгийн бага санал ирүүлсэн байгууллагыг сонгон шалгаруулсан хурлын тэмдэглэл үйлдэн, захиралд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн нь 10.0 сая төгрөгөөс дээш үнэ бүхий бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг хийхдээ харьцуулалтын аргыг ашиглан сонгон шалгаруулалт явуулж худалдан авах ёстой боловч үүнийг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчим”-ын 6 дугаар зүйлийн 6.4.4-д “Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэсэн зарчмыг мөрдөөгүй, мөн тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

